



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34
И-мэйл: info@sport.gov.mn

2023.09.08 № 01/726
танай _____ -ны № _____ -т

Г АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
ХОРООДЫН ДАРГА НАРТ

Г Удирдамж хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.5 дахь хэсэгт “Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ”, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын ўйл ажиллагааны удирдамжийг хүргүүлж байна.

Та бүхэн нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах, хэрэгжүүлэх талаар санаачилгатай ажиллана уу.

Удирдамжийг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА



142337886



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАЧАГ ЕНДЛЭМ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/268

Улаанбаатар хот

Г Аж ахуйн нэгж, байгууллага дахь
биеийн тамир, спортын үйл ажиллагааны
удирдамж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.


2. Удирдамжийг улсын хэмжээнд сурталчлах, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын удирдлагууд, Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс (О.Баасан)-т тус тус даалгасугай.


3. Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөмж болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын даргын 2017 оны А/82 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА





Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2023 оны 09 дүгээр сарын 08.-ны
өдрийн 10:00 дугаар тушаалын хавсралт

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ДАХЬ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.5 дахь хэсэгт "Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ" гэж заасан бөгөөд ажиллагсдын дунд зохион байгуулах биеийн тамир, спортын арга хэмжээ нь идэвхтэй амьдралын хэвшилтэй болгоход, хамт олны дунд биеийн тамир, спортын ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн байхаар батлагдсан.

1.2. Биеийн тамир, спортын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтын хүрээнд ажиллагсдыг идэвхтэй амьдралын хэвшилтэй болгох ээлтэй орчныг бүрдүүлж, байгууллагын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулахад дэмжлэг болохуйц хамт олны эерэг, зөв хандлага, ёс суртахууныг төлөвлүүлэхэд чиглүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагууд арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааны чиглэл

Аж ахуйн нэгж, байгууллага нь Хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлэхээр Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж болно.

2.1. Ажлын байрны онцлог нөхцөлтэй уялдуулан ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэхийг дараах байдлаар ойлгоно.

- 2.1.1. Материаллаг орчныг бүрдүүлэх;
- 2.1.2. Мэдлэг, зөв ойлголт өгөх сургалт, сурталчилгаа зохиох;
- 2.1.3. Сайн дурын үндсэн дээр биеийн тамирын арга зүйч ажиллуулах;
- 2.1.4. Ажилтнаар хавсран гүйцэтгүүлэх
- 2.1.5. Спортын клуб байгуулах.

2.2. Ажиллагсдын бие бялдрын түвшин тогтоох, байгаа түвшнээс бууруулахгүй байх, ахиулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх, ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, спортын тэмцээн зохион байгуулах;

- 2.2.1. Бие бялдрын сорилд хамруулах;
- 2.2.2. Дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх;
- 2.2.3. Тэмцээн зохион байгуулах;
- 2.2.4. Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцдоггүй ажиллагсдыг татан оролцуулах;
- 2.2.5. Үр дүнг үнэлэх, урамшуулах, алдаршуулах.

2.3. Байгууллагын нийт төсвөөс ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхэд зарцуулах;

2.3.1. Тогтмол хичээллэхэд чиглэсэн зардал;

2.3.2. Спортын арга хэмжээний зардал;

2.3.3. Орчныг бүрдүүлэх зардал.

Гурав. Зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагаа

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага, спорт клуб нь өөрийн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай нийцүүлэн хамт олны дунд зохиох биеийн тамир, спортын үйл ажиллагааг биеийн тамир, спортын салбарын эрх зүйн баримт бичигтэй уялдуулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

- Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйл;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" 53 дугаар Зарлиг;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 27 дугаар зарлиг;
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5.1 дэх заалт;
- "Чийрэгжүүлэх, бялдаржуулах байгууллага, үйлчилгээ" нийтлэг мөрдөх стандарт MNS 5538:2005;
- Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа биеийн тамир, спортын салбарын спортын төрлийн орчин, сургалтад тавигдах шаардлага;
- Улсын хэмжээнд зарлагдсан аян, арга хэмжээ, тэмцээний удирдамж;
- Салбарын дээд байгууллагаас ирүүлсэн эрх зүйн баримт бичиг;
- Бусад баримт бичиг.

3.2. Аж ахуйн нэгж, байгууллага, спорт клуб нь биеийн тамир, спортын нэгдсэн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцохдоо байгууллагынхаа лого, туг, тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг зохих хууль, журамд нийцүүлэн хэрэглэнэ.

3.3. Аж ахуйн нэгж, байгууллага, спорт клуб нь байгууллагын нэр, өмчлөлийн хэлбэр, байршил, утас, и-мэйл хаяг, биеийн тамирын арга зүйчтэй эсэх, ажиллагсдыг алдаршуулах, урамшуулах, спортын зэрэг цол олгох саналыг нутаг дэвсгэрийн харьяаллын аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын төрийн байгууллага, спортын холбоонд албан бичгээр жил бүр хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

3.4. Аж ахуйн нэгж, байгууллага, спорт клуб нь тухайн жилд биеийн тамир, спортын үйл ажиллагаанд зарцуулсан нийт зардал, бие бялдрын сорилд хамрагдагчдын үзүүлэлт, бие бялдрын үзүүлэлтийг ахиулахад хийсэн ажил, спортын арга хэмжээний төрөл, түүнд хамрагдсан ажилтны тоо зэрэг статистик тоон мэдээллийг багтаан тайлан гаргана.

3.5. Аж ахуйн нэгж, байгууллага, спорт клуб нь тухайн жилийн биеийн тамир, спортын үйл ажиллагааны тайлангаа үндсэн байгууллагын харьяаллын аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагад жил бүр хүргүүлэн, тухайн жилд зарлагдсан Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага шалгаруулах уралдааны шат шатны шалгаруулалтад оролцон дүгнэгдэнэ.